



CENTRAL
GEOLOGICAL
LABORATORY
www.cengeolab.com

Монголд эрдсийн шинжилгээний
тухай яригдвал

ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/6

Улаанбаатар хот

Г Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1-ийн 10, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. XVII жарны “Шар нохой” жилийн сар шинийн баярыг тохиолдуулан тус лабораторид ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэртээ гарсан 80-аас дээш насны 18 ахмадуудын нэрсийг 2-р хавсралтаар баталж, хүндэтгэл үзүүлж тус бүр 50,000 төгрөгийн тэтгэмж олгосугай.
2. Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх ажиллагааны төсвийг 1-р хавсралтаар баталж, төсвийн дагуу зохион байгуулахыг тасаг нэгжийн дарга нарт даалгасугай.
3. Сар шинийн баярыг тохиолдуулан тус лабораторийн ахмадын санд төсвийн дагуу 950,400 /есөн зуун тавин мянга дөрвөн зуу/ төгрөгийг төвлөрүүлсүгэй.
4. Төсвийн дагуу нийт ахмадуудад өгөх тэтгэмжийн 950,400 /есөн зуун тавин мянга дөрвөн зуу/ төгрөгийг Ахмадын сангаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнхтуяа/-д зөвшөөрсүгэй.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал /Л.Батзориг/, Техник хангамж, үйлчилгээ эрхэлсэн дэд захирал /Г.Бат-Эрдэнэ/ нарт даалгасугай.

ЗАХИРАЛ



Ө.ОЮУНБААТАР